



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: letter@moh.gov.mn, http://moh.gov.mn

2024.10.28 № 1а/4368
танай _____-ны № _____-т

Мэдээлэл, санал ирүүлэх тухай

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх үйл ажиллагааг Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлдэг болсон бөгөөд "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам"-ыг Засгийн газрын 2024 оны 78 дугаар тогтоолоор баталсан.

Энэхүү журамд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх төсөл, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг жил бүр батлан, уг тэргүүлэх чиглэлд нийцүүлэн төслүүдийг сонгон шалгаруулахаар заасан байдаг /2024 оны тэргүүлэх чиглэл ба шалгарсан 15 төсөл, арга хэмжээний мэдээллийг нэгдүгээр хавсралтаар хүргүүлснийг харна уу/.

Дээрх журамд төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтад оролцогч нь төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон нэгдсэн эмнэлэг байна гэж заасан тул энэхүү албан бичгийг нэгдсэн эмнэлэгүүд (төрийн болон хувийн) рүү уламжлан түгээж, хариуг шууд ирүүлэхээр даалгана уу.

Тус яамнаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх төсөл, үйл ажиллагааны 2025 оны тэргүүлэх чиглэлийн төслийг боловсруулж байна. Энэ тэргүүлэх чиглэлийг боловсруулахад шаардлагатай дор дурдсан мэдээллийг боловсруулж ирүүлнэ үү. Үүнд:

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний аль чиглэл, салбарт ямар төрлийн дэвшилтэт технологиуд хаана хаана нэвтэрсэн, түүнийг манай улсын хаана (төрөлжсөн мэргэшлийн болон нэгдсэн эмнэлгүүд) нэвтрүүлэх хэрэгцээтэй болон боломжтой байгаа тухай дэлгэрэнгүй танилцуулга,

141424652

2. Аль эмнэлэгт нэвтэрч нутагшсан ямар технологи, үйл ажиллагааг аль аймаг, орон нутгийн ямар эмнэлэг, байгууллагад нэвтрүүлэн нутагшуулах боломжтой тухай мэдээлэл, санал.


Түүнчлэн танай байгууллагад, эсхүл танайхтай хамтран хэрэгжүүлэх боломжтой, 2025-2026 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шинээр нэвтрүүлэх шаардлагатай дэвшилтэт технологийн төсөл, үйл ажиллагааны 3 хүртэлх тооны захиалгын саналыг хоёрдугаар хавсралтын дагуу бичиж ирүүлнэ үү. Захиалгын санал ирүүлэхдээ анхаарах зүйлс:

- а).Нэг төслийн захиалгын саналд төсөл, арга хэмжээний чиглэлээс хэдийг ч багтааж болно.
- б).Төслийн захиалгын саналыг нь зөвхөн нэр хэлбэрээр ирүүлэх ба тайлбар хэсэгт товч танилцуулгыг багтаана.
- в).Хэрэв 3-аас илүү тооны захиалгын санал ирүүлбэл, эхний 3-ыг автоматаар сонгоно.

Иймд дээрх танилцуулга, мэдээлэл, санал болон захиалгын саналыг бэлтгэн Удирдлагын эсхүл Эрдмийн зөвлөлийн хурлаараа хэлэлцүүлж, 11 дүгээр сарын 08-ны өдөрт багтаан тус яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын Анагаах ухааны инноваци, технологийн хэлтэст ирүүлнэ үү.

Нэмэлт мэдээлэл, лавлагаа шаардлагатай бол Эрүүл мэндийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн Нарийн бичгийн дарга Д.Ганзориг /Утас: 51-263136, 99145428, имэйл хаяг: ganzorig@moh.gov.mn/-той холбогдож тодруулна уу.

/Хавсралт 3 хуудастай/.



Т.МӨНХСАЙХАН

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн /18.06.2024/ тоот албан бичгийн нэгдүгээр хавсралт



Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх төсөл, үйл-ажиллагааны тэргүүлэх чиглэл ба шалгарсан төсөл, арга хэмжээнүүд (2024 он)

Дэвшилтэт технологийг нэвтрүүлэх тэргүүлэх чиглэл (2024 он)	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан байгууллага, баг
Зүрх, тархины судасны тогтолцооны эмгэг	Хүүхэд, нярайн зүрхний мэс засал	2024-2025 он	ЭХЭМҮТ
	Титэм судсан дотуурх хэт авиан шинжилгээг нэвтрүүлэх, нутагшуулах үндэслэл, Монгол улсын зүрх судасны өвчний өнөөгийн байдал, сургах хэрэгцээ	2024 он	УХТЭ
	Гол судасны мэс заслын чиглэлээр сургалт	2024-2025 он	УГТЭ
	Хүүхдийн зүрхний хэм алдагдлын үеийн электрофизиологийн оношилгоо, эмчилгээг нутагшуулах	2024 он	ЭНЭҮТ-2
	Нярайн тархи хөргөх эмчилгээг нутагшуулах	2024-2025 он	ЭХЭМҮТ
Хорт хавдар	Нярайн уушигны гипертензийн оношилгоо, эмчилгээг нутагшуулах	2024-2025 он	ЭХЭМҮТ
	Доод мөчдийн төрөлхийн хүнд хэлбэрийн согогууд, гэмтлийн дараах шагайн үеийн тогтворгүйтлийн үеийн мэс заслын эмчилгээ, доод мөчдийн дутуу хөгжил, ясны хавдрын нөхөн сэргээх мэс заслыг нутагшуулах	2024-2025 он	ГССҮТ

	Нейронавигаци, нейромониторинг ашиглан тархины гүний, төвөгтэй байрлалтай, гавлын суурийн хэсгийн хавдрын мэс засал эмчилгээг нэвтрүүлэх	2024-2025 он	УГТЭ
	Тархи, нугасны гүний байрлалтай хавдрын мэс заслын эмчилгээгээр гадаад сургалтад хамрагдах	2024-2025 он	ХСҮТ
	Хүзүү, сээр, бүсэлхий нурууны төрөлхийн хүнд хэлбэрийн мурийлтын мэс заслын эмчилгээг Монгол улсад нутагшуулах	2024-2025 он	ГССҮТ
	Хүүхдийн дээд болон доод мөчдийн хүнд хэлбэрийн төрөлхийн согогийн мэс засал эмчилгээг Монгол улсад нутагшуулах	2024-2025 он	ГССҮТ
Гэмтэл, согог	Толгой хүзүүний эрхтний согогийг гурван хэмжээст төлөвлөлт бүхий дижитал технологи ашиглан мэс засал болон согог заслын цогц аргаар нөхөн сэргээх эмчилгээг Монгол улсад нэвтрүүлэн нутагшуулах	2024-2025 он	ХСҮТ
Хүний геномикс/удамшлын эмгэг	Үр хөврөлийн удамзүйн оношилгооны аргуудыг эмнэлзүйд нэвтрүүлэх	2024-2025 он	ЭХЭМҮТ
	Меньерийн өвчний үеийн мэс заслын эмчилгээг Монгол улсад нутагшуулах	2024-2025 он	СЭМҮТ
Сэтгэц мэдрэлийн өвчин	Монгол улсад аутизм эмгэгийн оношилгоо, эмчилгээний шинэ аргыг нэвтрүүлэх	2024 он	СЭМҮТ

---oOo---

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 136/Т-тоот албан бичгийн хоёрдугаар хавсралт

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 2025 онд нэвтрүүлэх дэвшилтэт технологийн төсөл, арга хэмжээний санал

№	Төсөл, арга хэмжээний чиглэл	ТӨСЛҮҮД		
		Төсөл, арга хэмжээний санал 1 (нэрийг бичих)	Төсөл, арга хэмжээний санал 2 (нэрийг бичих)	Төсөл, арга хэмжээний санал 3 (нэрийг бичих)
1.	Монгол Улсад оношлогдож, эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийг оношлох, эмчлэх чадавхыг бүрдүүлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, шинэ арга, аргачлал нэвтрүүлэх			
2.	Монгол Улсад оношлогдож, эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийг оношлох, эмчлэх хүний нөөцийн чадавх бэхжүүлэх зорилгоор эмнэлгийн мэргэжилтнийг гадаад улс оронд сургах			
3.	Гадаад улс орны эмнэлгийн мэргэжилтнийг урьж ажиллуулан, дотоодын эмч нарт ажлын байрны сургалт зохион байгуулах			
4.	Орон нутагт оношилж, эмчлэх боломжгүй өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, эмнэлгийн мэргэжилтний чадавхыг бэхжүүлэх, технологи нутагшуулах зорилгоор төрөлжсөн мэргэшлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнг багаар нь орон нутагт ажиллуулах, инновацад шаардлагатай зарим техник, тоног төхөөрөмжөөр хангах			
5.	Дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, нутагшуулах явцад хийгдсэн оношилгоо, эмчилгээний зардлыг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх			
		Тайлбар	Тайлбар	Тайлбар

* - Ирүүлсэн захиалгын саналуудаас тэргүүлэх чиглэлд нийцсэн саналыг сонгон шалгаруулж, төсөл болгоно.